

УЛААНБААТАРЫН САНААЧИЛГА: ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОЛОМЖ БА ХЯЗГААР

Ц.Батбаяр*

Монгол Улс гадаад бодлогодоо олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг баримталдаг. Үүнд НҮБ-ын дүрэмд тусгагдсан зарчим, хэм хэмжээ эн тэргүүнд хамаарна. Монгол Улсын Гадаад бодлогын анхны үзэл баримтлал 1994 онд батлагдсан. Түүний шинэчилсэн найруулгыг 2011 оны 2 дугаар сард УИХ-аар батлав. Энэхүү үзэл баримтлалд “Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна” гэж заасан. Монгол Улс гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ дараах чиглэлийг баримтлана гэж заасан. Үүнд:

- ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, харилцааны өнөөгийн байдал, чиг хандлага, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах,

- АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх,

- Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;

*Ц.Батбаяр - Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлт, судалгааны газрын захирал, түүхийн шинжлэх ухааны доктор(Sc.D)

*Гадаад харилцааны яам, Конрад Аденауэр сангийн хамтран зохион байгуулсан симпозиумд тавьсан илтгэл

• НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх,

• Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ НҮБ, 77-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах.

Өдгөө Зүүн Хойд Азийн бүс нутагт байдал түргэн хурдацтай, хувьсан өөрчлөгдөж байна гэж бид үзэж байна. Энэ бүс нутагт газар нутгийн маргаан, хуваагдмал улсууд оршоор байна. Өнгөрсөн түүхээс өвлөж үлдсэн асуудлууд их байна. Харилцан итгэлцэл үгүй байна. Сенкаку буюу Дяоюйдао арлын эргэн тойронд болж буй үйл явдал энэ бүс нутагт яриа хэлэлцээ хичнээн их шаардлагатай байгааг батлан харуулж байна.

Манай ЗХА-ийн бүс нутагт цөмийн зэвсэг, пуужингийн асуудал гэх мэтээр олон хүнд хэцүү асуудал байна. Солонгосын хойгийн асуудлыг зохицуулах үүрэг бүхий зургаан талт яриа хэлэлцээ мухардмал байдалд оров.

Ийм нөхцөл байдалд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг энэ оны эхээр дэвшүүлсэн билээ. Энэ оны 4 дүгээр сард Улаанбаатарт болсон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сайд нарын бага хуралд үг хэлэхдээ дээрх санаачилгаа Ерөнхийлөгч дахин нотолсон билээ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам өдгөө энэхүү санаачилгыг тайлбарлаж таниулах сурталчлах, түүний мөн чанарыг ЗХА-ийн улс орнуудад ойлгуулахад чиглэсэн өргөн цар хүрээтэй ажил зохиож байна.

Монгол Улс ЗХА-ийн аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизм байгуулах талаар 1980-аад оноос эхлэн олон санаачилга гаргаж ирсэн. 2001 онд Зүүн хойд Азид энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн яриа хэлэлцээний механизм /track one буюу нэгдүгээр суваг/ байгуулах тухай санаачилга дэвшүүлж байсан.

2003 онд манай талаас ЗХА-ын хүрээнд асуудлыг дахин сөхсөн боловч тухайн үеийн байдлаас болж, хэрэгжиж чадаагүй юм. 2008 оны дөрөвдүгээр сард “Төв, Зүүн хойд Азийн аюулгүй байдлын ирээдүй: Улаанбаатар – Шинэ Хельсинк” сэдэвт олон улсын хурлыг Жорж Маршаллын нэрэмжит Европын аюулгүй байдал, олон улс судлалын төвтэй хамтран ҮАБЗ-ийн Стратегийн судалгааны хүрээлэн зохион байгуулж байсан. Энэ чиглэлд Монгол Улс дипломат шугамаар нэлээн хүч чармайлт тавьж ажилласны дүнд

Умард Солонгос – Японы хооронд харилцаагаа хэвийн болгох хоёр талын уулзалтыг Улаанбаатар хотноо хоёр удаа зохион байгуулж ЗХА-ийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын хүрээнд зургаан талт хэлэлцээг урагшлуулахад хувь нэмрээ оруулах үүднээс манай улс 2007 оны 9 дүгээр сард мөн 2012 онд БНАСАУ-Японы харилцааг хэвийн болгох асуудал эрхэлсэн хоёр талын ажлын хэсгийн хуралдааныг өөрийн улсад зохион байгуулсан ба энэ чиглэлээр хүч чармайлтаа цаашид ч тавих, тухайлбал ЗХА-ийн энх тайван, аюулгүй байдлын механизмын асуудал хариуцсан ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулахад бэлэн байгаа болно.

Өнөөдөр АСЕАН-ы Бүс нутгийн Чуулга/АРФ/ нь Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэх, бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн яриа хэлцээний олон талт механизм болж байна. АРФ нь зөвшилцлийн үндсэн дээр шийлвэр гаргадаг, мөн институтчлэгдсэн бүтэцгүй, чуулга уулзалт хэлбэрээр яриа хэлцээ явуулдаг зарчимтай. Гэхдээ энэ байгууллага маань ЗХА гэхээсээ илүү Зүүн Өмнөд Ази руу илүү чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Гэсэн хэдий ч АРФ-ын үйл ажиллагаанаас авах зүйл бас байгааг хэлэх ёстой.

АРФ-ын хүрээнд гишүүн улс орнуудын Сайд нарын уулзалт, Ахлах албан тушаалтны уулзалт жил бүр зохиогддог. Мөн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагаа, гамшгийн менежмент, их далайн аюулгүй байдал, үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах болон терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг асуудлаар чуулган хоорондын уулзалт тогтмол болдог. Мөн аюулгүй байдлын төрөл бүрийн асуудлаар семинар, уулзалтууд зохиогддог.

ЗХА-ийн аюулгүй байдлын асуудлаарх Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга нь Зүүн хойд Азид энх тайван, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн урт хугацааны зорилт бөгөөд Солонгосын хойг дахь түгшүүртэй байдлыг яриа хэлэлцээний замаар намжааж, энх тайванг тогтооход түүний үндсэн зорилго оршино.

Яриа хэлэлцээний гол зорилго бол ЗХА-д бүс нутгийн аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизм бий болгох явдалд оршино.

“Улаанбаатарын яриа хэлэлцээ” нь албан ёсны гэх нэгдүгээр суваг, албан бус гэгдэх эрдэмтэд, судлаачдын хоёрдугаар сувгийн аль алиныг оролцуулсан байх юм. Хойд Солонгосын цөмийн асуудлаарх зургаан талт яриа хэлэлцээ дан гани 1 дүгээр сувгаар явагдаж – талууд ойлголцолд бус, харин байр сууриа хамгаалахад гол анхаарлаа хандуулж байснаас тодорхой үр дүнд хүрээгүй гэж

үзнэ. Хоёр сувгийг хослуулах нь албаны хүмүүс, учир мэдэх судлаач, эрдэмтдийн хамт албан бус нөхцөлд асуудлыг илэн далангүй ярилцдаг – үр дүнд нь, талууд ойлголцолд хүрч, аль алиных нь сонирхолд нийцсэн гарцыг хайж олдогт оршино. Чухам ийм зөвлөлдөх механизм л ЗХА-д үгүйлэгдэж байгаа юм.

Яриа хэлэлцээний сэдвийн тухайд Улаанбаатарын яриа хэлэлцээ аюулгүй байдлын олон талт асуудлыг өргөн хамарна. Зургаан талт яриа хэлэлцээ дан ганц Умард Солонгосын Цөмийн хөтөлбөрийг хэлэлцэж, зогсооход л чиглэсэн байсан. Гэтэл ЗХА-д Умард Солонгосын цөмийн хөтөлбөрөөс өөр олон олон эрсдэл, сорилт тулгараад байна. Тиймээс Улаанбаатарын яриа хэлэлцээ:

- эдийн засгийн хамтын ажиллагаа,
- цэргийн тунгалаг байдал (military transparency),
- байгаль орчин,
- кибер аюулгүй байдал,
- сансрын аюулгүй байдал гэх мэт аюулгүй байдлын өргөн хүрээг хамарна гэж үзнэ.

Яриа хэлэлцээний оролцогч талуудын тухайд Улаанбаатарын яриа хэлэлцээг бодитой болгохын тулд нэгдүгээрт, хоёр талт яриа хэлэлцээг гурван талт болгох, аажмаар бусад улсыг яриа хэлэлцээнд оруулж, өргөжүүлэх замаар ажиллах зорилт тавьж байна.

Юун түрүүнд Умард Солонгос–Японы хоёр талын зөвлөлдөх уулзалтыг үргэлжлүүлэн зохион байгуулахыг эрмэлзэх болно.

Энэ уулзалтыг цаашид олон талт болгон өргөжүүлэхийн тулд хоёр талын уулзалт өндөрлөх үед Монголын тал гурав дахь тал болон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт зэрэг өөр асуудлаар санал солилцох замаар үргэлжлүүлж болох юм. Сүүлийн хэлэлцэх асуудал нь оролцогч талуудын аль алиных нь ашиг сонирхлыг татсан, гэхдээ санал зөрөлдөхөөргүй асуудал байх нь зүйтэй.

Ингэж хоёр талт уулзалтын араас гурван талт уулзалт зохиож, уламжлал болговол аажим оролцогчдын тоог нэмэх замаар олон талт болгох боломжтой юм гэж үзнэ.

Улаанбаатарын яриа хэлэлцээ ЗХА-ын зургаан орныг, тухайлбал, Орос, Хятад, Монгол, Япон, Умард Солонгос, Өмнөд Солонгосыг эхний ээлжинд хамарна. Гэхдээ бид “нээлттэй” байж, бүс нутгийн аюулгүй байдалд шууд сонирхол бүхий бусад улс, субъект нэгдэх асуудлыг дэс дараатай, шат шатаар ахиулна. Үүний дундаас БНАСАУ-тай итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд өөрийн харьцангуй давуу талд тулгуурлан түлхүү анхаарна.

Улаанбаатарын яриа хэлэлцээг БНСУ-ын дэвшүүлсэн

манайхтай төстэй санал, санаачилгатай уялдуулж, бие биенээ нөхсөн шинжийг нь практик бодлогоор бататгахыг эрмэлзэх болно.

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ энэ оны 5 дугаар сард АНУ-д айлчлах үеэр “Зүүн Хойд Азийн энхийн хамтын ажиллагааны олон талт яриа хэлэлцээ” (“Multilateral dialogue process in North-east Asia”) буюу “Сөүлийн процесс” санаачилгыг дэвшүүлсэн. “Сөүлийн процесс” санаачилгын үндсэн зорилго нь ЗХА-д хамтын ажиллагааны олон талт яриа хэлэлцээний бүтцийг бий болгоход чиглэгдэж байна. Энэхүү санаачилга нь ЗХА-ийн орнуудын эдийн засгийн харилцан хамаарал, дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг хурдацтай нэмэгдэж байгаатай зэрэгцэн түүх, газар нутгийн маргаан зэрэг улс төрийн асуудлаар улс хоорондын зөрчил улам хурдшаж “Азийн парадокс” үзэгдэл даамжирч байгаа нөхцөл байдлаас урган гарчээ. Ерөнхийлөгч Пак Гын Хэ эдгээр бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, бүс нутагт шинэ дэг журмын үндэс суурийг бүрдүүлэх арга зам нь АНУ болон ЗХА-ын орнууд юуны өмнө байгаль орчин, гамшиг, цөмийн эрчим хүчний аюулгүй байдал, терроризм зэрэг улс төрийн бус асуудлаар яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар харилцан итгэлцлийг бий болгох явдал гэж үзэж байна. ЗХА-д хамтын эрх ашиг, сонирхолд тулгуурласан итгэлцэл нэгэнт бүрэлдвэл хэтдээ улс төр, аюулгүй байдалтай холбоотой, зөрчил маргаантай том асуудлуудын харилцан ашигтай шийдлийг олох боломж нээгдэх юм гэж Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч үзэж байгаа юм.

Монгол Улс 2012 онд Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад /ЕАБХАБ/ нэгдэн орсон билээ. ЕАБХАБ-ын суурийг тавьсан гол үйл явц бол Хельсинкийн процесс байсан юм.

Бид орчин үеийн олон улсын харилцааны түүх, туршлагаас суралцах ёстой. Бид өөр тивийн туршлагыг сохроор хуулах гээгүй. Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Ази өөрийн гэсэн онцлогтой гэдгийг бид ойлгож байна. Европ тив ялангуяа энх тайвнаар зэрэгцэн оршихын сургамжтай жишээг үзүүлж байгаа билээ. 1970-аад оны үед Зэвсэглэлээр хөөцөлдөхийг хазаарлаж, түр намжмал байдал үүсгэсэн Хельсинкийн үйл явц эдүгээ ЕАБХАБ болон хөгжиж ирснийг жишээлэн ЗХА-д Солонгосын хойгийн хурцалмал бэрхшээлийг шийдэх, улмаар Зүүн Азийн аюулгүй байдлыг ярилцаж байх яриа хэлэлцээний бүтцийг бүрэлдүүлэхийг бид зорьж байна. Хельсинкийн процесс арав гаруй жилийн чармайлт шаардсан байдаг. ЗХА-д ийм үйл явцыг эхлүүлэхэд, магадгүй үүнээс ч илүү

олон жил шаардагдаж мэднэ. Гэхдээ яриа хэлэлцээний механизмийг бий болгохын төлөө одооноос ажиллаж эхлэх хэрэгтэй гэж ойлгож байна.

Хельсинкийн процессийн жишээ, түүний сургамжаас сурах, санаа авах зүйл нэлээдгүй байна.

Юуны өмнө Хельсинкийн Төгсгөлийн баримт бичигт орсон зарчмууд бидний анхаарлыг татаж байгаа юм. Тэдгээр зарчмуудаас бие биеийн харилцаанд хүч үл хэрэглэх, маргаантай асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх, өөр хоорондоо өргөн хамтын ажиллагаа хөгжүүлэх зэрэг зарчмууд өдгөө ЗХА-ийн нөхцөлд ихээхэн үгүйлэгдэж байна. Ийм хамтын ажиллагаа улс төр-аюулгүй байдал, эдийн засаг-технологи, соёл-хүмүүнлэгийн гэх Хельсинкийн “гурван сарг” /three baskets/ ихээхэн үүрэгтэй. Ийм хамтын ажиллагааг Азид хэрэгжүүлэхэд болохгүй гэх газаргүй гэж санана.

Бид 2014 онд бүс нутгийн улс орнуудын эрдэмтэд судлаачдын оролцоотойгоор томоохон эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Мөн түүнчлэн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар мэргэшсэн эрдэмтэд судлаачдыг “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санал санаачилгыг сурталчлах ажилд оролцуулах, тэднийг Монголд урих, холбогдох албаны хүмүүстэй уулзуулах ажил зохион байгуулахаар манай хилийн чанд дахь ДТГ-ууд ажиллаж байна.

Олон улсын энхийн хүрээлэн (International Peace Institute)-тэй хамтран, мөн Конрад Аденауерын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын оролцоотой судалгааны хурал, семинар зохион байгуулахаар бид ажиллаж байна.

Гадагшаа харсан үйл ажиллагааны зэрэгцээ мөн бид дотоодын байгууллагуудад ажиллагсдын мэргэжлийн чадавхи, санаачилгын тухай ойлголтыг гүнзгийрүүлж дээшлүүлэх тал дээр анхаарах болно. Энэ талаар Capacity building чиглэлээр үндэсний семинарийг ирэх оны эхээр хийхээр төлөвлөж байна.

Манай ойрын түнш Герман зэрэг оронд суугаа ДТГ-ууд Монгол Улсын санал санаачилгын явц байдлын талаар байнга мэдээлж, шаардлагатай үед тэдгээрийн туслалцаа дэмжлэгийг авах хэрэгцээ ч гарч магадгүй юм.

Ази, Номхон далай бол 21 дүгээр зуунд дэлхийн хөгжлийг тодорхойлох чиг хандлагатай байгаа бөгөөд үүний тулд энэ бүс нутагт олон улсын эрх зүй давамгайлж, зөвшилцөл, хамтран ажиллах явдлыг дээдлэх нь юу юунаас чухал юм. Монгол Улсын санаачилга чухамдаа үүнд чиглэж байгаа билээ.